

ЦАГ ҮЕ БА МЕТАФОРЧЛАХ СЭТГЭЛГЭЭ

Ц.Магсар¹

Утга зохиолын онол, хэлний прагматик судалгааг хөдөлгөөнд оруулсан нэг шинэлэг чиглэл бол 1980-аадоноос өргөн далайцтай хөгжих болсон метафорын онолын судалгаа юм. Утга зохиол судлалыг хагас зуун жил гаруйтай барьж байсан улс төр – үзэл суртлын хүлээс тайларсан ерээд оноос манай судлаачдын нэг хэсгийн дотор утга зохиолын онолыг бараг л метафорын онолоор төлөөлүүлж үзэх үзэл дэлгэрснийг буруутгах арга байхгүй. Үүнийг өгүүлэгч миний бие мөнхүү үзлийг үгүйсгэдэггүй нэгэн байсны хувьд барууны метафор судлаач Ж.Лакоф, М.Жонсон нарын бичсэн, сонсч мэдсэн ч уншиж үзээгүй “Та бидэнд амин чухал метафор” хэмээх олныг ихэд шуугиулсан ном Вашингтон хотын нэгэн номын дэлгүүрт байсантай таарч олзуурхан авснаа эргүүлж тойруулж үзэх зуур төрсөн алаг цоог бодлоо тэмдэглэн үлдээхийг зүйд үзэв.

Монгол хэл, соёлын судлалд метафор хэмээх ухагдахууныг “адилтгал”, “зүйрлэл” гэсэн хоёр салаа ойлголтоор, заримдаа “адилтгал зүйрлэл” гэсэн хоршоо үгээр дүйцүүлэн хэрэглэж ирсэн боловч барууны судлаачдын хэрэглэж ирсэн концепт буюу шинжлэх ухааны ойлгоцын хүрээгээр нь тодорхойлж үзье гэвэл тийм ч оновчтой биш мэт. Иймд энэ үгийг орчуулья гэсэнгүй. Хэл судлаачдын энэ талаар бичсэнийг сонирхвол доктор, профессор Ж.Баянсан мөн ийм бодолтой байдаг бололтой. Учир нь адилтгах, зүйрлэх, тойруулах, төлөөлүүлэх зэрэг хэлний найруулгын олон арга бол метафорыг бүтээх л хэрэглүүр. Дашрамд хэлэхэд шинжлэх ухааны хэрэглээнд байнгын эргэлтэнд орсон ороогүй үй олон гадаад нэр томъёог концептийнх нь зааг ялгааны учир начрыг сайтар олоогүй байж бүгдийг дайлаар монголчлох явдал сурагч оюутнуудын байтугай судлаачдын өөрсдийнх нь толгойг эргүүлэхүйц яршиг төвөг үүсгэдгийг хэн хүнгүй мэднэ. Жишээ нь контекст (context) хэмээх ойлгоцыг хэл шинжлэлд үгийн утгын хүрээлэл талаас нь чухалчлан “хам сэдэв” гэдэг нэр томъёогоор орчуулан хэрэглэж ирсэн, энэ нь үндсэндээ хэвшсэн. Гэтэл орчин үед энэхүү нэр томъёог бусад шинжлэх ухаан physical context, historical context, cultural context, personal context, interpersonal context гэх мэтчилэн өргөн хэрэглэх болсон нь анхлан монголчилсон нэр томъёо, түүний концепт хоёрын хооронд зөрөө үүсгэсэн байдал ажиглагддаг. Энэ мэтчилэн шинэ цагийн утга зохиол судлалд өргөн хэрэглэх болсон Гуссерлийн “объектив коррелят”, “интенци”, Элиотын имперсонал онол гэх юм уу эсвэл постмодернизмын интертекст, нонселекц, деконструкц, ризома мэтийн олон ойлголтыг концептийнх нь агууламжийг хадгалан орчуулж хэрэглэнэ гэхэд хэцүү. Энэ байдал харин математик, байгалийн шинжлэх ухаанд харьцангуй асуудал багатай, ихэнхдээ олон улсын нэр томъёогоо барьж хэвшсэн байдаг тул шинжлэх ухааны хэрэглээндээ ч, сургалтандаа ч нэг ёсондоо амар бололтой байдаг.

1. Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Лакофын онолоор метафор (герег хэлний *metaphora* буюу “шилжүүлэлт” гэсэн үгнээс гаралтай) гэдэг ойлгоцыг хэл шинжлэл, найруулгазүйн судалгааны хүрээнд бидний ойлгож ярьж ирсэн уламжлалт ойлгоцоос ихээхэн өөрөөр авч үзсэн бөгөөд энэ нь уг онолыг тойрсон маргаан, янз бүрийн мэтгэл үзэл урсгалууд үүсэх сэжиг болсон. Үүгээрээ ч судлаач, сонирхогчдын анхаарлыг ихэд татсан бололтой. Үүнийг тодруулах үүднээс түүний зарим нэг концептуаль чанартай үзэл номлолыг сийрүүлж үзье.

- Метафорын мөн чанар нь нэг юмны гол шинжийг өөр зүйлд оноож ойлгож хүлээж авахад оршино... Метафор нь зөвхөн хэлэнд буюу өөрөөр хэлбэл үгэнд хамаарах төдий зүйл биш. **Хүний сэтгэхүйн үйл явц нэлэнхүйдээ метафорчлагдсан байдаг.** (1, pp. 5-6).
- ...бидний туршлага, үйл ажиллагааны дийлэнх нь уг чанартаа метафорчлагдсан, хүний ойлголтын тогтолцооны ихэнх нь метафорын тусламжтай бүтэцчилэгдсэн. (1, p. 147).
- ...метафор төсөө (*similarity*) үүсгэдэг ба тэр нь туршлагын өөр өөр ангилал бүхий зүйлсийн хооронд байдаг ерийн төсөөнөөс нэлээн хол ойлголт юм. Энэхүү бодит байдлаас холдсон төсөө нь бүтэцтэй. Түүнээс гадна метафор... төсөөний шинэ төрөл үүсгэдэг. **Метафор төсөө үүсгэдэг тухай бидний онол өнөө хэр өргөн тархаад байгаа зүйрлэлийн онол буюу метафорын сонгодог онолтой таарахгүй.** (1, pp. 147-152).
- Метафор бол хүн юмыг ойлгоход амин чухал зүйл, та бидний амьдралд **шинэ бодит байдал, шинэ утга үүсэх нэг механизм** (*mechanism for creating new meaning and new realities in our lives*) гэж бид үзнэ. (1, p. 195-196). Метафор бодит байдлыг үүсгэж болох тухай үзэл санаа метафорын талаарх уламжлалт үзлийн дийлэнх ихэнхтэй таарахгүй. Таарахгүйн шалтгаан нь өмнөх үзэл онолууд метафорыг хэлэнд хамааруулж үзэж ирсэн, харин хүний ойлголтын тогтолцоог бүтэцчилэх хэрэгсэл талаас нь юм уу, бидний хийж гүйцэтгэдэг өдөр тутмын үйлтэй холбож үзэж байсангүй. Уг дангаараа байхдаа л бодит байдлыг өөрчлөхгүй гэж үзвэл зүйд нийцнэ. ...Соёлоор тодорхойлогдох нийгмийн бодит байдал биег бодит байдлын талаарх өөрт нь агуулагдаж буй үзэл төсөөллүүдэд нөлөөлж байдаг нь гайхаад байх зүйл биш. Аливаа соёлыг төлөөлж буй хүний хувьд (*member of a culture*) бодит зүйл гэдэг бол нийгмийн бодит байдал ч, бодит ертөнцтэй харьцах туршлагаа хэрэгжүүлэх арга ч аль аль нь үйлийн үр дүн болно. Тэгвэл нийгмийн бодит байдлын ихэнхийг бид метафорчлагдсан нэр томъёогоор хүлээж авдаг, бодит ертөнцийн талаарх төсөөлөл маань хэсэг бусгаар метафорчлагдсан гэдэг нь үнэн бол оршин байгаа бүхний бодитой гэдгийг тогтооход метафор л чухал үүрэг гүйцэтгэнэ. (1, pp. 145-146).
- Метафорг бидний туршлагын зарим талыг товойлгон тодруулж (*to highlight*), хооронд нь уялдуулдаг (*to make coherent*) тийм үр дагаврууд байна. Зарим метафорын хувьд бидний туршлагын чухамхүү талуудыг товойлгон тодруулж, уялдаадараалалд оруулдаг нь илэрхийллийн цорын ганц арга ч байж мэднэ. Мөн **метафор та бидний хувьд бодит байдлыг** (*realities*) **бүтээж, онцгойлон хэлэхэд нийгмийн бодит байдлыг** (*social realities*) **бүтээж болно.** Метафор бас та биднийг ирээдүйн үйл рүү нь чиглүүдэгч болж чадна. Мэдээж ийм үйл метафортаа зохирч байх болно. ...Энэ утгаараа метафор хар аяндаа гүйцэлдэж шидтэй эд. Зөвхөн улс төр, хайр сэтгэл гэлтгүй амьдралын ямар ч хүрээнд бодит байдлыг метафор хэлбэрээр тодорхойлж, дараа нь тэр метафорчилсан сэтгэлгээрээ (*on the basis of the metaphors*) үйлдлээ гүйцэтгэдэг. (1, pp. 156-158).
- ... уг чанартаа метафор ухагдахуунт (*conceptual*) шинжтэй. **Метафор нь юмыг ойлгох чухал хэрэгсэл, нийгэм, улс төрийн бодит байдлыг бүрэлдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг** (*they play a central role in the construction of social and political reality*). Философг тэдгээрийг өнөө хүртэл “зүгээр л хэлний” зүйл (*matters of “mere language”*) мэтээр үзэж ирсэн бөгөөд метафорын талаарх философийн хэлэлцээн (*discussions*) түүний ухагдахуунт чанар, юмыг ойлгоход болон соёлын бодит байдалд гүйцэтгэж буй үүрэгт огт төвлөрч байсангүй. Харин ч философчид метафорыг ямарвааг ер бусын байдлаар дүрслэн үзүүлсэн, хэлний яруу илэрхийлэл гэж үзэх хандлагатай явж ирсэн бөгөөд тэдний хэлэлцээн хэлний

иймэрхүү илэрхийллүүд үнэн байж чадах эсэх дээр л тогтож төвлөрдөг байв. (1, р. 159).

Энд авсан ишлэлүүдээс үзэхэд Лакофын онол утга зохиол судлал, хэрэглээний хэл шинжлэлд бидний ярьж ойлгож ирсэн адилтгал зүйрлэлийн тухай ойлголтоос эрс ялгаатай байна. Лакоф онолоо эмпиризмд суурилуулсан тул хэрэглэж буй тулгуур ойлголтуудаа (experience, metaphorical concepts, metaphorical and cultural coherence, creation of similarity, human conceptual system, experiential gestalts, interactional properties) хүн, нийгмийн оюун санаанд хуримтлагдсан туршлага, танин мэдэхүйн сэрэл мэдрэхүйн талыг түлхүү барьж томъёолсон бөгөөд хүн харилцаандаа метафор хэрэглэх, хүний сэтгэлгээ метафорчлагдах үйлийн үндсийг үндэсний хэлтэй нь биш, сэтгэлгээний хэв шинж, соёлын менталитеттэй нь илүүтэй холбож үзжээ. Тэрээр когнитив онолын үүднээс метафорыг бодит байдлыг танин мэдэх хэрэгсэл, хүний туршлагыг эрэмбэлж, ертөнцийн талаарх мэдлэг төсөөллийг бүтэцчилэх багаж хэмээн онцгойлон үзсэн байна. Метафорыг бүтцийн (structural metaphors), чигийн (orientational metaphors), онтолог (ontological metaphors) гэж үндсэнд нь ангилан үзэхдээ бидэнд уламжлан ирсэн хэлний дүрслэлийн чанараар нь биш, концептлаг чанараар нь (хүний ой тойнд туршлагаас бүрэлдсэн дүрслэлт төсөөлөл буюу гештальтын тусламжтай) шинжлэн тайлбарлаж, үүндээ “мөн чанарын бүтэц” (entity structure), “чигийн бүтэц” (orientational structure), “туршлагын хэмжээсүүд” (dimensions of experience), “туршлагын гештальтууд” (experiential gestalts), “суурь” (background), “чухалчлан товойлгох” (highlighting), “интерактив шинж” (interactional properties), “эх загвар (дүр)” (prototype) гэх мэт тулгуур ойлголтуудыг хэрэглэжээ.

Лакофын дэвшүүлсэн өөр нэг санаа бол хэл сэтгэлгээг метафорчлах үйл явц юу юунаас түрүүн нийгэм, улс төрийн хүрээнд дэлгэрэх хандлагатай байдаг ба энэ нь нийгмийн хөгжлийн өгсөх буурах үе мөчлөгийг дагаж өрнөх магадлалтай тухай үзэл юм. Энэ үүднээс монголын нийгэмд цаг үеийг дагасан метафорчлах сэтгэлгээ ямар янзтай байгааг төсөөлөн харах зорилгоор хэсэгхэн жишээ түүснийгээ дор өгөв.

“Цаг үе ба метафорчлах сэтгэлгээ” сэдвийн хүрээнд бид уран зохиол, яруу найргийн метафорчилсан дүрслэлийг шинжиж ярихаа урьтал болгосонгүй. Учир нь уран зохиолын метафорчлал зохиол бүтэхийн амин сүнс болж байдаг тул цаг үеийн хамаарал багатай, гоо зүйн сэтгэлгээний хөгжил, сод авьяастнуудын эрэл хайгуул, бүтээл туурвилтай холбогдсон шалтгаануудтай гэж үзвэл зохино. Жишээ нь монголын нийгэм, улс төр бараг зогсонги байдалд ортлоо царцаж тогтворжсон ХХ зууны наяд онд Бавуугийн Лхагвасүрэн зэргийн билиг оюунт найрагчид гэхэд л *салхи шилрэх, салхи наадах, үүл майлах, зүүд гаслах, мочир дуниш, мичид хөглөрөх, түүх зүүрмэглэх, үдшийн бүрэнхий гэгээ хивэх, уснаас саран залгилах, цэцэгс нар зүүдлэн зүүрмэглэх, билүү цээжээрээ салхи ирлэх, салхины хөл хүндрэх, нарны хийлш манхан, нар дугшиж үлдсэн бүлээн барагшин* гэх мэт хэл сэтгэлгээний талаасаа язгуурлаг шинжтэй нэн содон метафор хэрэглэсэн байдаг. Мэдээж бүтцийн талаас нь шинжвэл дээрх метафорыг бүтээгч үгс дангаараа бие даасан обьектив утгатай, ердөө л хэлний юм уу үгсийн сангийн нэгж. Гэтэл нийлэмжийн түвшиндээ утгын обьектив чанараа алдаж сэтгэлгээний субъектив чанарыг олж байгаа нь сонин. Метафорын ийм субъектив дүрслэл түүнийг хэрэглэгч хүн хүнд магадгүй өөр өөр төсөөг (тухайлбал мэдлэг, туршлагын олон талаас нь хамааран) төрүүлж болно. Энэ тохиолдолд метафорын концептлаг шинж, тэр нь хүний сэтгэхүүд өөрийн гэсэн өнгө төрхтэй төсөө үүсгэн очиж уялдахын тухайд ярих хэрэгтэй болж байгаа юм.

Бид монголын нийгэм хөдөлгөөнд орсон ерээд оноос хойш дэлгэрсэн, ингэхдээ зарим нэг нь бүр монгол хэлний (харь эх үүсвэртэй ч) өвөрмөц хэллэг болтлоо бэхжсэн, бас нэг хэсэг нь хэлний хэрэглээнд урьд өмнө байсан идиом идэвхжих буюу өөр өнгө төрхтэй болж хэрэглэгдэх болсон цөөн тооны метафорыг уншигчдын анхааралд толилуулж байна. Бас нэг сонирхолтой нь энэхүү метафоруудын онтолог мөн чанарыг анзаарвал нийгмийн амьдралын толь болохуйц гэмээр ерөнхий нэг дүр зураг ажиглагдаж байна. Тэдгээрийг ямар ч байдлаар сэдэвчилж болох боловч дараах хэдэн чиглэлд хамруулав.

Нийгмийн сэтгэл зүйд хамаарах нь: дүүрэн (дундуур) амьдрал, баттай эх сурвалж, нийгмийн задрал, цагийн салхи, хаврын синдром, дээдэс, буу халах, будаа болох (болгох), хуцах, боорлох, арсалдах, хэмхэлдэх, яс булаалдах, хадуурах, бүсээ чангалах, сэтгэлээ чангалах, уруудах, амьдрал доошлох, доош нь чихэх, шатах, унаж босох, ноён нуруу хугарах, хөл алдах, хөсөр хаягдах, хог дээр гарах, стресст орох, өөдлөх, өндөр авах, амьдрал дээшлэх, оргилд гарах, ноён суух, хйош (араар) суух, хомоол хамах, суулт зарлах, (ордон тойрч) гороолох, татаж босгох, шөвөлзөх, шогтох, урагшаа (хойшоо) харах, орчноо мэдрэх, од харвах, шаазан хагарах, нийгэм бухимдах, эргэлзээ төрүүлэх, бор шувуу нисгэх, шуугиан тарих (дэгдээх), нүднээс далд орох, ёсчлох, хэлбэрдэх, халтуурдах, нүд хуурах, үнэгүйдүүлэх, царцаах, шоудах, газар авах, хүрээгээ тэлэх, хаданд гарах, шүд зуух, цайх, улалзах, улайрах, ногоорох, түгжрэх, чавхдах, гол гаргах, гутлаа чирэх (хормойгоо чирэх гэдгээс), гудамж метрлэх, гэдэс гарах, ямба эдлэх, нүд үзүүрлэх, галд тос нэмэх, хулхидах, салхи сөрөх (уруудах), турхирах, хариугаа авах, хариу барих, улсаа самрах, жүжиг тавих, долоолгох, архинд орох, архинаас гарах, тасрах, архидалттай тэмцэх, тодрох, айдаст автах, уур хилэн нь бадрах, зовлонд унах, сэв суух, гүйдэлтэй болох, чимэг зүүх, дүрээ мөнхлөх, шагналын хур буух гэх мэт.

Улс төрд хамаарах нь: гүйгүүл, чөдөр, зиндаа, аргамжаа (уяа), гох дэгээ, хаялга, сул гишүүн, горилогч, зөөлөн сэнтий, өнгөт хувьсгал, улс төрийн харх, олигарх, албан тушаалын дон, халаасны хүн, нэр цэвэр хүн, боловсон хүчний хомсдол, нялхсын өвчин (нялхрах), унтаа улс төр, улс төрийн хожоо, сайн засаглал, сайдын марафон, сөрөг хүчин, улс төржүүлэх, улс төр хийх, бойкотлох, золиослох, гацаа үүсгэх, хориг тавих, зангуу тавих, буланд шахах, цоорох, хадуурах, туших (уях), өчих, гарших, данхайх, новшрох, цадах, пологтох, идэж уух, мөнгө идэх, хар мөр үлдээх, төсөл унагах, төсөл өргөн барих, хуульд гар хүрэх, томилгоо хийх, нэр дэвших (дэвшүүлэх), нэр сэвтэх (баасдах), алсын хараа дугах, хэлсэн амнаасаа буцах, догтоод 'хэрэгт' хутгалдах, 'тоглолт' хийх, 'дүрд тоглох', 'газардах', 'туйлшрах', 'имижээ' алдах, пиар хийх, байраа тавих, нутаг сэлгэх, өвөр түрийндээ орох, хөнжлөө хувааж нөмрөх, төр түвшин засаг бүтэн ажиллах, ачаа даах, хүчин зүтгэх, хүч үзэх, төр гүших, алба хаших, лааз өшиглөх, нөлөөнд автах, дөрлүүлэх, очоод наалдчих, тал засах, аялдах, дарамтанд орох, төрийн албыг вакуумжуулах, албан хаагчдаа хомрогolon халах, эсэргүүцэлтэй тулгарах, нүүр царайгаа илчлэх, маскаа хуулах, зэс нь цухуйх, арьсаа хамгаалах, зай тавих, лай болох, хир халдаах, сор залах, цэц булаалдах, мөрөө хоох, яс хаях, ан цав гарах, цээжээ дэлдэх, хор найруулах, салаавч өгөх, тахимаа өгөх, олонхиороо түрий барих, ногоон гэрлээр гарах, халуун тогоон догтроо ярих, найр тавих, чармайлт гаргах, сандал ширээтэйгээ зууралдах, санал өгөх, завсарлага авах, толгой хоргодох, бодлогоор дэмжих, улаан шугам татах гэх мэт.

Эдийн засагт хамаарах нь: Таван голгойн ралин, амин дэм, тоглогч, цөм сүрэг, өндөр үзүүлэлт, эмзэг бүлэг, хүч хөрөнгө зарах, талаар болох, үргүй зарах, доллар сулрах, ханш унах (тогтворгүйгэх), хонгилын үзүүрт гэрэласах, итгэл найдварын гал дүрэлзэх (цог анивчих), эрсдэл хүлээх, цаг зарах, цаг алдах, хөрөнгө үрэх, хөрөнгө оруулах, зардлаа танах, боломж алдах, хүний нөөцийг эргэлтэд оруулах, гар сунгах, хуруу хөдөлгөх, буруу замаар будаа тээх, эдийн засаг халах, эдийн засаг аюулын бүсд орох, данс улайх, гал алдах, босго давах, мөнгө босгох, төсөвт тусгах, нүүрсээр амьсгалах, баялгийнхаа хэргийг гаргах, сорох, ядуурал буурах, ядууралд өртөх, хямралд өртөх, хохирол хүлээх, гал унтраах, урагш алхах, өртөг шингэх, жин дарах гэх мэт.

Хуульд хамаарах нь: цоорхой хууль, эрх зүйн орчин, хөөн хэлэлцэх хугацаа, хуулийн цоорхойг ашиглах, чавчих, тулгах, авилгадах, (хахууль) өгч авах, хэрэг хүлээлгэх, өгөөш (мэн) хаях, цэг тавих, хэрэг хаах, хараанд авах, шантаажлах, гүрийх, гол дүрд тоглох, харцаараа байлгах, асуудалд орооцолдох, хөзрөө дэлгэх, тоглоомоос гарах, барьцаа лавшруулах, ээдрээг гаргах,

утасны үзүүр олох, хар буух, чулуу хөөлгөх, аминд хүрэх, хохирол амсах, дээлээ нөмрөх, тэнсэн харгалзах, замхруулах, уснаас хуурай гарах, хэрэг хуучрах, хэрэгсэхгүй болгох гэх мэт.

Бизнес хамаарах нь: тул, акул, хулгар, жараахай, червяк, борлуулах цэг, бохир мөнгө, мөнгө угаах, гахай чирэх, тендер алдах, тендер унах, тендер шаах, амиа хоохойлох, хар толгойгоо бодох, ялаас бултах (мултлах), татвараас зайлсхийх, хэд нугалах, ашгаа нуух, нэрвэгдэх, хөлд чирэгдэх, боорлуулах, гуйвуулах, зувчуулах, хөл дээрээ босох, элгээрээ хэвтэх, нүцгэн гараар үзэлцэх, улаан гараараа үзэх, шувтрах, унжих, шовойх, шавхах, шантатах, хоолойд дээрхутгатавих, багалзуурдах, онхолдуулах, сөхрөх, томрох, юманд хүрэх, дампууралд хүргэх, цээжний хожоо хийх, санаанд багтах, хог болох, ажил уях, бэл заах, бяд суух, од шүүрэх, (барааг) бөөндөх (дарах) гэх мэт.

Энэ бол цаг үеийн шалтгаанаар идэвхжсэн, үүгээрээ тухайн цаг үеийн тусгал, бодит байдлын толь болсон метафорууд. Эдгээр тус бүрт агуулагдаж байгаа концепт (ойлгоц) хэмжээснйхээ хувьд өөр өөр боловч тухайн цагийн мэдлэг туршлагын хуримтлалыг тусгасан байдалд нь дүн шинжилгээ хийвэл нийгмийн амьдралын олон салбар, янз бүрийн үзэгдлийг суурь мэдээлэл буюу гешталыг хэлбэрээр өөртөө шингээсэн гэдэг нь маргаангүй ойлгомжтой. Бас тэдгээрийг ямар эрэмбэ дараалалд оруулснаас нийгмийн бодит байдалд үүссэн түүхэн нөхцөл байдлын явцыг ямар нэг байдлаар тодорхойлж болох талтай байна. Ингэхийн тулд метафорын судалгаанд тухайн метафорын үүслийг (буюу идэвхжлийг) бүртгэх хэрэгтэй гэсэн үг.

Үндэсний хэлний түүхэнд харь үг нутагших, тэдгээр нь их багаасаа шалтгаалан үнтэтсний хэл, сэтгэхүйд эерэг сөрөг ямар нэг байдлаар нөлөөлөх бол түгээмэл үзэгдэл. Даяаршлын үйл явц, дэлхийн нэгдсэн мэдээллийн сүлжээний хөгжил хурдсах болсон өнөө цагт ийм нөлөөллийг хянах, хазаарлах боломжгүй боллоо. Тэгвэл метафорчлах сэтгэлгээ бас харь сэтгэлгээнээс орж ирж нутагшдаг байна. Ийнхүү нутагшихдаа эх концептээ хадгалдаг ч, эх хадгалдаг ч бололтой юм. Мэдээж үүнд цаг хугацааны болон ахуй, соёл, сэтгэлзүйн хүчин зүйл голлох нөлөөтэй. Бас ийм үйл явцын уг сурвалжийг соёл хоорондын харилцаанаас хайх хэрэгтэй байх. Монголын түүхийн нэг хэсэг зурвас дорнын соёлтой, нөгөө хэсэг нь оросын соёлтой холбоотой байсан. Харин өнөө цагийн нийгэм америк маягийн барууны соёлтой илүүтэй их холбоотой байгаа бөгөөд соёл хоорондын харилцааны түүхэн зурвас тус бүрээс метафорчлах сэтгэлгээ (түүний илэрхийллийн хэлбэр нь орчуулагдсан орчуулагдаагүй янз бүр) шилжин суурьшсан баримт олныг олж болно. Жишээ нь өнөө цагт идэвхтэй хэрэглээнд байгаа заримаас нь дурьдвал: загалмайлсан эцэг (God father), хөгжлийн түлхүүр (development code), түлхүүр тоглогч (key player), уур амьсгал (climate), хөгжлийн өдөөгч (growth catalyst), алтан боломж (golden chance), генсек, боевик, спикер (speaker), рейтинг (rating), санхүүгийн ертөнц (financial world), матрын нулимс унагах (to shed crocodile tears), нэгдсэн вант улс (united kingdom), чээнж (change), улс төрийн шоу, шоудах, пиардах (PR), лоббидох (lobby), крандах, данхраадах, шантаажлах, канселдах (cancel), мухардалд орох (попасть в тупик), нагдааванд (накаунд) оруулах (knockout), ертөнцөөс тасрах (the outside world), имижээ өсгөх (to create an image), *галт тэрэг нэгэнт хөдлөх (поезд уиёл)* гэх мэт. Эдгээрээс жишээ нь "чээнж" гэдэг концептыг авч үзэхэд англи хэлнийхээ change, exchange утгаасаа ихэд холдсон, монгол үндэсний гэмээр шинэ реал буюу өөр өнгө төрхтэй концепт үүсгэсэн байдаг. Зөвхөн энэ хэдэн метафораас гэхэд л "боевик", "шоудах", "улс төрийн шоу", "пиардах", "лоббидох", "шантаажлах", "крандах", "данхраадуулах", "нагдааванд оруулах", "ертөнцөөс тасрах" зэрэг метафор хэдийгээр зээлдмэл ч одоо монгол төрхтэй, монголжсон концепт болжээ.

Метафорын нэг өвөрмөц хэлбэр бол төлөөлөл (metonymy). Төлөөллийг бүрэлдүүлж буй концепт өөрийн гэсэн өнгө төрх, агууламжтай, түүнийгээ дагасан үр дагавартай байна. Жишээ нь төлөөллийн саяхан үүссэн шинэ хэлбэр "МАНАН" (МАН+АН), "будан" (манангийн хувилбар метафор) хэмээх концептүүд гэхэд л өнөөдөр нийгмийн сэтгэлзүйд бүрэлдээд байгаа эерэг гэхээсээ илүү сөрөг нэлээн олон талын мэдээллийн агууламжтай байна. Өөр хэлбэрийн

Ц.Магсар

нэг төлөөлөл болох эздийг нь компанийх нь нэрээр юм уу, олны танил хүмүүсийг нийгэмд бүрдүүлсэн имижээр нь хочлон нэрлэх байдал энэ цаг үеийн сэтгэлгээний түгээмэл үзэгдэл болжээ. Тэгэхдээ тухайн хүнийг нэрээр нь нэрлэх, хочилсон төлөөлөл нэрээр нь нэрлэхийн хооронд концептийн мэдээжийн ялгаа байна. Жишээ нь “*фортуна*”, “*ажнай*” гэвэл энэ компаний эздийг нэрээр нь нэрлэхээс өөр агууламжтай концепт үүсгэнэ. Мөн *анарх*, *олигарх*, *нахал* гэх мэт нэршсэн концептүүд хэрэглээндээ нийгэмд бараг бухимдал үүсгэх үр дагавартай байх жишээтэй.

Ийнхүү метафор хэрхэн яаж цаг үеийн болон бодит байдлын тусгал болдгийг бид Лакофын нэрд гарсан орчин үеийн онолын үзэл нөлөөгөөр тайлбарлахыг оролдов. Ийнхүү нийгмийн сэтгэлгээнд гарч буй өөрчлөлт, үндэсний соёл, сэтгэхүйн толь болж хэвлэлийн хуудаснаа дэлгэрсэн бүтцийн олон янзын хэлбэр, шинж бүхий метафор, мөн уран зохиол, яруу найраг дахь метафорын танин мэдэхүйн судалгааны нэгэн шинэлэг чиглэл манайд эзнээ хүлээж байна.

АШИГЛАСАН ЭХ

1. Lakoff, G. & Johnson, M. *Metaphors we live by*. The University of Chicago Press. 2003.
2. Lakoff, G. *The contemporary theory of metaphor // Metaphor and thought*. Ed. by Ortony A. Cambridge University Press. 1993.
3. Теория метафоры. М., 1990.
4. Ж.Баянсан. Хэлний соёл судлалын үндсэн асуудал. www.greenbough.mn/article.php?content=77.

ABSTRACT

The article comments some ideas of George Lakoff and Mark Johnson's work – “*Metaphors We Live By*” became a new trend of theoretical research in last thirty years of metaphor studies and it analyzes how the metaphor reflects the current social circumstances in Mongolia. Mongolian language incorporates rich metaphors as many other languages, however, research work in terms of their structure and cognition is occasional. The author has observed and exemplified some metaphors applicable in social and political frames that are widely used in Mongolian journalism and developed a relevant thematic classification in his article. By his article, author suggests that further development of cognitive researches on metaphors is recommended in future literature studies and pragmatic linguistics.